

Үзүүлэлтүүд:

ДНБ 1.4% 2016 оны II-р улирал урьдчилсан гүйцэтгэлээр	ГШХО 8-р сард 19.2 сая ам.доллар	Төсвийн алдагдал -2051 тэрбум төгрөг	Инфляци -0.1%	Чанаргүй зээл 1059 тэрбум төгрөг	Валютын нөөц 1 тэрбум ам.доллар
Уул уурхайн салбар 9.1 хувь, барилгын салбар 4.4 хувь, хөдөө аж ахуйн салбар 3.5 хувь тус тус өссөн нь нөлөөлөв.	Цэвэр ГШХО 8-р сарын байдлаар 19.2 сая ам.доллар болж өмнөх сараас буурсан үзүүлэлттэй гарч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.4 сая ам.доллараар өсөв.	Төсвийн орлого 4012 тэрбум төгрөг, зарлага 6064 тэрбум төгрөг болж тэнцэл (2051) тэрбум төгрөгийн алдагдалтай гарав.	Өмнөх сараас 0.6 хувь буурч, оны эхнээс 0.6 хувь өсч өмнөх оны мөн үеэс 0.1 хувь буурсан байна.	Чанаргүй зээлийн хэмжээ өмнөх сараас 0.8 хувь буюу 8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 1059 тэрбум төгрөгт хүрэв. Нийт зээлд эзлэх чанаргүй зээл 8.5% байна.	Монголбанкны валютын нөөц 9-р сард өмнөх сараас 4.3 хувь буюу 50 сая ам.доллараар буурч 1092 сая ам.доллар болов.



Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш

2244 ₮



Орон сууцны үнийн индекс

1.013

Өмнөх сараас 0.19%-иар буурч, өмнөх оны мөн үеэс 7.3%-иар буурлаа.




Монголбанкны бодлогын хүү

15%

Хэрэглээний үнийн индекс сүүлийн 24 сар дараалан буурч, жилийн өөрчлөлт 2009 оноос хойш анх удаа дефляцитай гарав. Тодруулбал инфляцийн жилийн өөрчлөлт тайлант сард -0.2-оос -0.6 хувьд хүрч, дефляцитай гарав. Өмнө нь 2009 оны 9 дүгээр сард улсын болон Улаанбаатар хотын инфляци -1.9 хувьд хүрч байсан удаатай.

Экспортод гаргадаг гол түүхий эдийн үнэ, хэмжээ

Манай улсын экспортын гол бүтээгдэхүүний сар тутмын экспортын хэмжээ болон дундаж үнийг графикаар, хүснэгтээр оны эцсийн байдлаар үзүүлээ.



Сүүлийн 3 жилийн хугацаанд МУ-ын экспортын түүхий эд, өссөн дүнгээр (тэрбум ам.доллар, сая тонн)

Голлох бүтээгдэхүүн	2014 он		2015 он		2016 оны 9-р сар	
	Хэмжээ	Орлого	Хэмжээ	Орлого	Хэмжээ	Орлого
Чулуун нүүрс	19.5	0.8	14.4	0.6	16.1	5.0
Төмрийн хүдэр	6.3	0.4	6.3	0.2	4.2	1.7
Зэсийн баяжмал	1.4	2.5	1.4	2.3	1.2	1.3
Нийт	27	4	22	3	22	8


Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Үнэт цаасны зах зээлийн үнэлгээ энэ оны эхний хагас жилийн байдлаар 1.4 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14.6 тэрбум төгрөг буюу 1.03 хувиар өсчээ.

ДНБ ДНБ 2016 оны 2-р улирлын байдлаар (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 7.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 121.9 тэрбум төгрөгөөр өсч эдийн засгийн өсөлт 1.4 хувь болов. ДНБ-ий 1.4 хувиар өсөхөд аж үйлдвэр, барилгын салбарын нэмэгдэл өртөг 4.4 хувь, үүнээс уул уурхайн салбарынх 9.1 хувь, хөдөө аж ахуйн салбарынх 3.5 хувиар өссөн нь голлон нөлөөлөв.



Төсөв Улсын нэгдсэн төсвийн орлого өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 0.8% буурсан бол зарлага 23.4% өссөн нь төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 2051 тэрбум төгрөгийн алдагдалтай гарахад хүргэлээ. Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеийнхээс 1184 тэрбум төгрөгөөр өсөхөд орлого 0.8 хувиар буурч, зарлага 23.4 хувиар нэмэгдсэн нь нөлөөлөв.




Валютын ханш

Есдүгээр сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 250 төгрөг буюу 12.5 хувиар нэмэгдэж, өмнөх сартай харьцуулахад 55 төгрөг буюу 2.5 хувиар өсч 2243.98 төгрөгөөр сулрав.



Инфляци


Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2016 оны 9-р сард өмнөх сараас 0.6 хувь буурч, өмнөх оны мөн үеэс 0.1 хувь буурч, өмнөх оны эцсээс 0.6 хувь буурав. Үнийн дундаж түвшин өмнөх сартай харьцуулахад 0.6 хувиар буурахад хүнсний бараа, ундаа, усны үнэ 2.8 хувь, үүнээс төмс, хүнсний ногооны дэд бүлгийн үнэ 11.9 хувь, мах, махан бүтээгдэхүүнийх 7.1 хувиар буурсан нь голлон нөлөөлөв.



* Урьдчилсан гүйцэтгэл; Эх сурвалж ҮСХ, Монголбанк

Гадаад валютын нөөц


Гадаад валютын улсын албан нөөц 2016 оны 9-р сарын байдлаар 1092 сая ам.доллар болов. Энэ нь өмнөх сараас 4.3 хувь буюу 50 сая ам.доллараар буурч, өнгөрсөн оны мөн үеэс 22.7 хувь буюу 320 сая ам.доллараар буурсан үзүүлэлттэй байна.



* Эх сурвалж Монголбанк

MSE-20 индекс

2016 оны есдүгээр сард 1.8 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдэж, өмнөх сарынхаас 1.1 тэрбум төг буюу 2.5 дахин өсчээ. ТОП-20 дундаж индекс 2016 оны есдүгээр сард 11539 нэгж болж, өмнөх сарынхаас 919, өмнөх оны мөн үеийнхээс 1671 нэгжээр буурчээ.



* Монголын хөрөнгийн бирж

Мөнгө

Мөнгөний нийлүүлэлт (M2) мөнгө өмнөх оны мөн үеэс 15.2 хувиар, өнгөрсөн сараас 1.7 хувиар нэмэгдэж 11.4 их наяд төгрөгт хүрэв. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө өнгөрсөн оныхоос 3.6 хувиар нэмэгдсэн бол өмнөх сараас 2.6 буурч, нийт мөнгөний 7 хувийг эзэлж байна. Өмнөх сартай харьцуулахад төгрөгийн хадгаламж бага зэрэг өсөх хандлагатай байна.



Хадгаламж

Нийт хадгаламж 2016 оны 9-р сард 8.1 их наяд төгрөг болж өмнөх сараас 1.8 тэрбум болов. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 11.4 хувиар буюу 830.9 тэрбум төгрөгөөр өсөв. Өмнөх сараас валютын хадгаламж 3.9 хувиар буюу 98.6 тэрбум төгрөгөөр буурч, төгрөгийн хадгаламж 1.8 хувиар буюу 100.4 тэрбум төгрөгөөр өсчээ.



Зээл

ААН, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2016 оны 9-р сард өмнөх сарынхаас 0.1 хувь, өнгөрсөн оны мөн үеэс 3.9 хувиар нэмэгдэж 12 их наяд төгрөг болов. Чанаргүй зээлийн хэмжээ 1059 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 0.8 хувиар, өнгөрсөн оны мөн үеэс 26.6 хувь тус тус нэмэгдэв. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 8.5% байна.



Ипотекийн зээл

2016 оны 9-р сарын байдлаар нийт ипотекийн зээлийн үлдэгдэл өмнөх сараас 1.3 хувь (49.5 тэрбум төгрөг), өмнөх оны мөн үеэс 18.8 хувь (623.3 тэрбум төгрөг)-өөр нэмэгдэж нийт 3.9 их наяд төгрөгт хүрэв. Есдүгээр сард нийт 1704 зээлдэгчид 49.5 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгож, нийт зээлдэгчдийн тоо 87925-д хүрэв. 2016 оны есдүгээр сарын байдлаар ипотекийн зээлийн үлдэгдлийн 99 хувь нь төгрөгийн зээл, 1 хувь нь валютын зээл байна. Ипотекийн зээлийн үлдэгдэлд эзлэх хугацаа хэтэрсэн зээлийн хувь тайлант сард 2.3 хувь, чанаргүй зээлийн эзлэх хувь 1.1 байна.




Гадаад худалдаа

Гадаад худалдаа

2016 оны эхний есөн сарын байдлаар нийт барааны эргэлт 5780 сая ам.доллар, үүнээс экспорт 3332 сая ам.доллар, импорт 2448 сая ам.долларт хүрч гадаад худалдааны тэнцэл 884 сая ам.долларын ашигтай гарлаа. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 9.6 хувь, экспортын хэмжээ 5.8 хувиар, импортын хэмжээ 14.3 хувиар тус тус буурчээ. Эрдэс бүтээгдэхүүн, үнэт, хагас үнэт чулуу, металл гоёлын зүйлсийн экспорт нийт экспортын 84.4 хувийг эзэлж байгаа бол импортын 53.9 хувийг эрдэс бүтээгдэхүүн, машин тоног төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд ангийн импорт эзэлж байна.

Гадаад худалдаа




* Эх сурвалж УЦХ, Монголбанк

Гадаадын шууд хөрөнгө оруулалт

Гадаадын шууд хөрөнгө оруулалт 2016 оны 8-р сард 19.2 сая ам.доллар болж өмнөх сараас буурсан үзүүлэлттэй байна. Харин өмнөх оны мөн үеэс 3.4 сая ам.доллараар өсөв. Гадаадын шууд хөрөнгө оруулалтад МУ-аас гадаад руу гаргасан хөрөнгө оруулалт -0.3 сая ам.доллар байв.


Гадаадын шууд хөрөнгө оруулалт



* Эх сурвалж Монголбанк

Монгол Улсын гадаад өр**Гадаад өр**

2016 оны хоёрдугаар улиралд Засгийн газрын нийт гадаад өр 4 тэрбум ам.доллар, Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 23.4 тэрбум ам.доллар болсон байна. Энэ нь өмнөх улирлаас ЗГ-ын өр 17 хувь (670 сая ам.доллар), Улсын нийт гадаад өр 4 хувь (850 сая ам.доллар)-иар тус тус буурсан байна. Тайлант улиралд нийт Улсын гадаад өрийн 20 хувийг засгийн газрын өр, 7 хувийг Төв банкны өр, 9 хувийг хадгаламжийн байгууллагуудын өр, 34 хувийг бусад салбаруудын өр, 29 хувийг компани хоорондын зээллэгийн өр тус тус эзэлж байна. Төв банкны нийт өрийн 96 хувийг богино хугацаат, 4 хувийг урт хугацаат өглөг эзэлж байна.



* Эх сурвалж Монголбанк

Сарын онцлох үйл явдал

9.16

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж 2016 оны 9 дүгээр сарын 15-18-нд Бүгд Найрамдах Куба Улсад албан ёсны айлчлал хийв. Айлчлалын хүрээнд Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Бүгд Найрамдах Куба Улсын Төрийн Зөвлөл болон Сайд нарын Зөвлөлийн дарга Раул Кастротой албан ёсны хэлэлцээ хийж, Кубын үндэсний баатар Хосе Мартигийн хөшөөнд хүндэтгэл үзүүлж, цэцэг өргөв.

9.23

Зуны цагийн хуваарь есдүгээр сарын 23-наас 24-нд шилжих шөнийн 00.00 цаг хүртэл үргэлжилж, улмаар өвлийн цагийн хуваарьт шилжив.

9.28

Засгийн газрын өнөөдрийн хуралдаанаар Ипотекийн зээлээр орон сууц худалдан авахыг зохицуулсан Засгийн газрын тогтоолд зарим өөрчлөлт оруулж орон сууцны талбайн дээд хязгаар өмнө нь 80 ам.метр кв байсныг өөрчилж дээд хязгаарыг 100 ам.метр кв, зээлийн хүүг 8 хувь байхаар тогтоов.

9.28

Дэлхийн эдийн засгийн форум” байгууллагаас жил бүр гаргадаг судалгаагаар Монгол Улсын өрсөлдөх чадварт ахиц гараагүйг нээлттэй нийгэм форумаас танилцуулав. Манай улс өрсөлдөх чадвараар 3.8 оноо авч, 138 орноос 102 дугаарт эрэмбэлэгдэв. Өнгөрсөн жилийн судалгаагаар Монгол Улс өрсөлдөх чадвараараа 104-т эрэмбэлэгдсэн.